

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДЭЛХИЙН ӨДӨР

ХУЭМТ-ийн даргын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/65 дугаар тушаалаар “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр”-ийг зохион байгуулах ажлын хүрээнд 13 ажлыг төлөвлөн биелэлт 100% байна.



Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын зорилтууд





2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Эрүүл мэндийн төвийн гадна талбайд Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөрт зориулсан “Оношлогоог зөв , аюулгүй хийе” уриан доор өдөрлөгийг зохион байгууллаа.

Өдөрлөгийн хүрээнд Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилтын дагуу ХСХА, эм зүйн алба, сувилахуйн алба, хэвтэн эмчлүүлэх тасаг, амбулаторийн тасгууд тус бүр 10 минутын танилцуулгыг хийж өдөрлөгт 200 гаруй эмч, эмнэлгийн ажилтнууд болон үйлчлүүлэгчдэд танилцуулж сургалт сурталчилгааны материал тараалаа.





ЭМТ-ийн нийгмийн ажилтан Мөнхзаяа, тархвар судлаач С.Өлзийжаргал нар Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6 зорилтын хүрээнд видео бичлэг хийсэн байна.



Мөн өдөрлөгийн үеийн цахим хандалт 3709 хүн хамрагдсан байна.

